

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Төрийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг бүрдүүлж ажиллалаа. 2024-2025 оны өвөлжилтийн бэлэн байдлыг хангахтай холбоотой ОНӨАТҮГ аас 3000 боодол өвс авахаар гэрээ байгуулан ажиллав.

Эрүүл хүнс алтан намар шилмэл мал үзэсгэлэн худалдаа 09 дүгээр сарын 20-21 ний өдрүүдэд барууг урт суманд зохион байгуулагдаж тус үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцлоо.

Сумын төвийн засмал замын гэрэлтүүлэг хүлээн авах ажлыг 9 дүгээр сарын 15-17 ны өдрүүдэд зохион байгуулан ажлын хэсэг хүлээн авлаа.

Сумын сонгуулийн хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдлаа. Мөн 4 хэсгийн хороог байгуулан 9 дүгээр сарын 26 ны өдөр 14 цагт Иргэний танхимд сонгуулийн хэсгийн хороонд ажиллах албан хаагч нарт сумын сонгуулийн хороо сургалт мэдээлэл өгөхөөр ажиллаж байна.

Е- Mongoloia: Цахим системээс Иргэний үнэмлэхийн лавлагаа – 11, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа - 2, жолооны үнэмлэхийн лавлагаа-2, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт – 10, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа – 5, НАХЯ-ны хилийн ба дотоодын цэрэгт цэргийн алба хаасан тухай архивын лавлагаа - 0 , нийт – 30 лавлагаа олголоо.

Пэйж хуудсанд энэ сар нийт 20 пост(мэдээ мэдээлэл) оруулсан. Халзан сумын албан ёсны вэб сайт болох Khalzan.su.gov.mn хандах эрхийг олж авч веб сайтны хөгжүүлэлт болон нэмэх зүйл дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХНУМС-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, албан хаагчдын орон нутагт ажилласаны нэмэгдлийг шинэчлэн орууллаа.

9 дугаар сард нийт ирсэн бичиг 16, хариутай -5, үүнээс хугацаанд нь илгээсэн -4, хугацаа болоогүй -1, явсан бичиг -10 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

Аймгаас санхүүгийн дэмжлэгээр 0.0 мянган төгрөгийн санхүүжилт ирж. Татварын орлогоор 94444.2 мянган төгрөг

Орон нутгийн төсвийн байгууллагад 122661.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.

1. ИТХ - 16189.7
2. ЗДТГ - 82424.5
3. Хүүхдийн цэцэрлэг – 5500.0
4. Сургууль – 14650.0
5. ЭМТ – 2916.6
6. Соёлын төв – 980.6

Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/195 тоот захирамжаар батлагдсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 1 тендер зарлагдаж гэрээ байгуулсан боловч одоогоор үйл ажиллагаа эхлээгүй байна. Мөн нэг тендер зарлагдах шатандаа явж байна

Сумын ЗДТГ, ИТХ-ын ажилчдад 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны талаар төсвийн тайланг тавьж ажилласан.

Мөн 2024 оны төсвийн тодотголыг 9 сарын 24-ны өдөр оруулахаар бэлтгэх ажил ханган ажиллаж байна.

2024 оны 09 сарын 18-20 өдрүүдэд Сангийн яамнаас зохион байгуулсан богино хэмжээний ТАЦНС-ийн сургалтанд санхүү албаны бүх гишүүд хамрагдсан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Дотоод хяналт шалгалтын тухай хуулиудаар мэдээлэл өгч ажиллалаа.

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД:

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ 09/25 ны өдөр тус суманд ажиллалаа. 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн хүүхэд хамгааллын шинэ хуулийн танилцуулга, шинэлэг, онцлог заалтууд, тус хуулийн 22 дугаар зүйл гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгаалал" хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотой сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг"-т тус хуулийн 23 дугаар зүйл боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал", байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хөдөлмөрийн хуулийн 43.3 - т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хүүхдийн сурах, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах, орчны аюулгүй байдал, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, согтуурах, мансуурах, аливаа төрлийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн төрийн албан хаагч, баг, зөвлөл, иргэдтэй хамтран зохион байгуулах, архины хамааралтай, дагавар, тавиул, хараа хяналт сул, ахуйн хүрээний архидалт, хүүхдийн дэргэд архиан согтуурах зэрэг сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч ажиллах, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг тогтмолжуулах, зэрэг сургалт, мэдээлэл, зөвлөмж арга зүй өглөө

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр батлагдсан малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчдын мал хүлээлцэх ажлыг зохион байгуулж батлагдсан 26 өрхөөс 24 өрхийн мал хүлээлцэн акт үйлдсэн.

ХАБЭА-н зөвлөлөөс 2024.09.12 нд Албан даалгаврын биелэлт ирүүлэх албан бичгийн хүрээнд ЗДТГ-ын ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Д. Дайриймаа мэргэжилтэнтэй хамт Халзан суманд үйл ажиллагаа явуулж байгаа Молцог элс, Артус ХХК-д албан даалгарын биелэлт болон Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчын Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах тухай албан бичгийг хүргүүлж ХАБЭА-н хэм хэмжээг хэрэгжүүлж ажиллах талаар мэдээлэл өглөө.

“Ажил олгогч, бизнес “ эрхлэгчдийн бүсийн зөвөлгөөнд Түмэнцогт суманд Засаг дарга Г. Алтансүхээр ахлуулсан бизнес эрхлэгч, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт хамрагдсан 12 хүний бүрэлдэхүүнтэй бүсийн зөвөлгөөнд амжилттай оролцож Гал бадрах өөдөө ХХК нь Халзан суманд 10 гаруй ажлын байрыг бий болгож Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдаж Бүсийн зөвөлгөөнд амжилттай оролцсон

Ахмадын баярыг угтан Халзан суманд байгаа Харъяалалгүй ахмадын судалгааг Ахмадын хорооны даргатай тулгалт хийж шинээр 27 ахмадыг хөдөлмөр халамжийн Ehalamj системд шинээр бүртгэж ажиллалаа.

Байгаль орчны чиглэлээр: Соёлын зориулалтаар шонхор шувуу барих 3 отгыг шалгаж 7 шувууны гэрээ байгуулан акт бичиж 100121100946 тоот дансанд 4 шонхор шувууны 83 520 000 төгрөг тагтааны хураамж 178 000 төгрөгийг тус төвлөрүүлсэн. Улсын тэмдэгтийн хураамжинд 3 915 000 төгрөгийн хураамж оруулсан.

Мөн дээрхи отгуудад Аймгийн БОАЖГ-тай хамтран үзлэг шалгалтыг явуулсан

Мэргэжлийн ангийн бие бүрэлдхүүний судалгааг гарган аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн

Тал хээрийн зэрлэг амьтан судлах төв болон аймгийн БОАЖГ-тай хамтран Монгол тарваганы байршлыг тогтоох өсөлтөнд хяналт тавьж тооллого явуулсан

Сэг зэм устгалын цэгүүдийн координатыг тогтоон аймгийн БОАЖГ-т хүргүүлсэн

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
Д.ДАЙРИЙМАА